

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2022/136/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг  
2022 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд  
Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр  
Утас: 7034-2580 Цахим хаяг: [ankhbayard@audit.gov.mn](mailto:ankhbayard@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас: 7034-2716 Цахим хаяг: [enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:enkhtsoodolj@audit.gov.mn)

Аудитор: Г.Цэрэнлхам  
Утас: 7034-2495 Цахим хаяг: [Tserenlkhamg@audit.gov.mn](mailto:Tserenlkhamg@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

## **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БУА	Булган аймаг
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НА	Нийцлийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХГБХЗХ	Хүүхэд гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-3259  
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 96  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

БУГАТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Ч.ОДОНТУЯА ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


D:/bichighereg/2022A4toot

006000162

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>81,951,536.50</b>	<b>77,623,474.63</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	780,800.00	-
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	780,800.00	-
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	780,800.00	-
31213	Арилжааны банк дахь харилцах	780,800.00	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	6,858,890.75	4,883,190.28
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	5,264,335.65	3,665,965.88
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1,594,555.10	1,217,224.40
3351	Байгууллагаас авах авлага	1,594,555.10	1,217,224.40
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	74,311,845.75	72,740,284.35
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	49,791,845.75	48,220,284.35
35410	Бичиг хэргийн материал	2,725,985.00	1,701,300.00
35420	Аж ахуйн материал	44,015,060.75	44,382,984.35
35430	Сэлбэг хэрэгсэл	3,050,800.00	2,136,000.00
35600	Мал амьтад	24,520,000.00	24,520,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,094,039,369.44</b>	<b>1,235,244,301.08</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,094,039,369.44	1,235,244,301.08
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	960,827,369.44	1,102,212,301.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	858,975,758.10	974,945,004.10
39202	Хуримтлагдсан элэгдэл	(189,221,870.95)	(229,722,807.10)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	215,983,983.37	230,983,983.37
39204	Хуримтлагдсан элэгдэл	(156,217,833.59)	(168,258,282.85)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	100,797,320.35	135,463,644.35
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40,076,200.17)	(63,723,131.57)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,732,738.12	31,276,021.79
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,574,880.16)	(18,128,107.52)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	16,280,000.00	16,280,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	274,882,958.28	358,280,152.28
39215	Хуримтлагдсан элэгдэл	(133,619,203.91)	(166,118,775.77)
39217	Ном	884,600.00	934,600.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	133,212,000.00	133,032,000.00
39301	Програм хангамж	3,495,500.00	3,495,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,775,500.00)	(2,955,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	132,492,000.00	132,492,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>	<b>1,175,990,905.94</b>	<b>1,312,867,775.71</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,487,040.00</b>	<b>827,709.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,487,040.00	827,709.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,487,040.00	827,709.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	50,000.00	634,709.00

41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	303,840.00	130,000.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>1,133,200.00</b>	<b>63,000.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	1,133,200.00	63,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,174,503,865.94</b>	<b>1,312,040,066.71</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,174,503,865.94</b>	<b>1,312,040,066.71</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	667,249,599.55	667,249,599.55
51101	Өмч: - төрийн	667,249,599.55	667,249,599.55
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>59,576,604.77</b>	<b>197,112,805.54</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	59,576,604.77	59,576,604.77
51220	Тайлант үеийн үр дүн	-	137,536,200.77
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	447,677,661.62	447,677,661.62
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,175,990,905.94</b>	<b>1,312,867,775.71</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>535,712,803.13</b>	<b>637,533,605.67</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>38,255,085.13</b>	<b>258,137,967.67</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>36,353,516.13</b>	<b>258,137,967.67</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	36,353,516.13	258,137,967.67
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,312,865.00	8,555,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	32,040,651.13	249,582,367.67
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		249,086,367.67
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		496,000.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>1,901,569.00</b>	<b>-</b>
122001	Хандив тусламж /дотоод/	1,901,569.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>495,687,418.00</b>	<b>379,395,638.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>105,717,900.00</b>	<b>21,700,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	71,310,000.00	-
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	34,407,900.00	21,700,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>37,648,418.00</b>	<b>14,862,038.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,144,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,602,349.00	1,141,288.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,901,569.00	13,720,750.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>352,321,100.00</b>	<b>342,833,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	352,321,100.00	342,833,600.00

<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>515,164,535.84</b>	<b>499,997,404.90</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>515,164,535.84</b>	<b>499,997,404.90</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	509,066,146.31	492,978,592.98
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	228,921,107.18	209,319,312.00
210101	Үндсэн цалин	155,870,452.38	151,933,497.48
210102	Нэмэгдэл	31,187,423.80	41,385,765.52
210105	Гэрээт ажлын хөлс	41,863,231.00	16,000,049.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29,503,826.82	28,076,451.05
210201	Тэтгэврийн даатгал	19,859,299.10	19,838,974.04
210202	Тэтгэмжийн даатгал	2,349,684.93	2,087,339.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,813,429.73	1,702,155.84
210204	Ажилгүйдлийн даатгал	478,260.51	404,361.92
210205	Эрүүл мэндийн даатгал	5,003,152.55	4,043,619.36
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	28,450,755.47	45,913,786.90
210301	Гэрэл, цахилгаан	8,753,923.47	4,556,964.90
210302	Түлш, халаалт	19,696,832.00	41,356,822.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	27,554,160.00	22,616,735.50
210401	Бичиг хэрэг	4,008,350.00	4,891,585.00
210402	Тээвэр, шатахуун	15,032,450.00	14,307,450.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,629,600.00	1,410,820.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	1,416,920.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,748,860.00	589,960.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	134,900.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	1,030,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,030,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	15,936,870.00	6,404,850.00
210604	Урсгал засвар	15,936,870.00	6,404,850.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,934,000.00	1,984,000.00
210701	Гадаад албан томилолт	3,000,000.00	-
210702	Дотоод албан томилолт	934,000.00	1,984,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,505,309.00	4,321,440.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,554,849.00	1,146,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	379,400.00	364,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	124,200.00	131,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	122,860.00	132,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,100,000.00
210807	Газрын төлбөр	-	446,740.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	171,260,117.84	173,312,017.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,419,089.00	60,439,301.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,543,400.00	451,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	104,297,628.84	112,421,116.03

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,098,389.53	7,018,811.92
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,098,389.53	7,018,811.92
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,098,389.53	7,018,811.92
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	20,548,267.29	137,536,200.77

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	667,249,599.55	447,677,661.62	59,576,604.77	1,174,503,865.94
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	667,249,599.55	447,677,661.62	59,576,604.77	1,174,503,865.94
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	667,249,599.55	447,677,661.62	59,576,604.77	1,174,503,865.94
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	137,536,200.77	137,536,200.77
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	667,249,599.55	447,677,661.62	197,112,805.54	1,312,040,66.71

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>428,690,283.00</b>	<b>387,951,238.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,312,865.00</b>	<b>8,555,600.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4,312,865.00	8,555,600.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	4,312,865.00	8,555,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,312,865.00	8,555,600.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>424,377,418.00</b>	<b>379,395,638.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	105,717,900.00	21,700,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	71,310,000.00	-
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	34,407,900.00	21,700,000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	37,648,418.00	14,862,038.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,144,500.00	-

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,602,349.00	1,141,288.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,901,569.00	13,720,750.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>386,729,000.00</b>	<b>342,833,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	386,729,000.00	342,833,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>421,859,583.00</b>	<b>384,192,358.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>421,859,583.00</b>	<b>384,192,358.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>415,761,193.47</b>	<b>377,173,546.08</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>234,273,885.28</b>	<b>206,971,452.48</b>
210101	Үндсэн цалин	153,931,570.20	150,015,497.48
210102	Нэмэгдэл	40,982,823.08	40,955,906.00
210105	Гэрээт ажлын хөлс	39,359,492.00	16,000,049.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>29,678,684.72</b>	<b>27,595,231.80</b>
210201	Тэтгэврийн даатгал	20,284,100.00	19,252,521.66
210202	Тэтгэмжийн даатгал	2,348,665.93	2,092,779.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,878,856.73	1,674,356.70
210204	Ажилгүйдлийн даатгал	469,732.20	451,360.51
210205	Эрүүл мэндийн даатгал	4,697,329.86	4,124,213.57
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>22,715,165.47</b>	<b>45,913,786.90</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,926,923.47	4,556,964.90
210302	Түлш, халаалт	13,788,242.00	41,356,822.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>17,746,610.00</b>	<b>16,690,647.90</b>
210401	Бичиг хэрэг	4,094,150.00	3,659,800.00
210402	Тээвэр, шатахуун	12,023,700.00	8,985,675.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,628,760.00	1,547,171.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	1,499,920.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	998,081.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>600,000.00</b>	<b>600,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	600,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>28,275,390.00</b>	<b>2,505,800.00</b>
210604	Урсгал засвар	28,275,390.00	2,505,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,934,000.00</b>	<b>1,984,000.00</b>
210701	Гадаад албан томилолт	3,000,000.00	-
210702	Дотоод албан томилолт	934,000.00	1,984,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,402,809.00</b>	<b>3,174,740.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,452,349.00	-

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	379,400.00	364,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	124,200.00	131,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	122,860.00	132,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,100,000.00
210807	Газрын төлбөр	-	446,740.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>73,134,649.00</b>	<b>71,737,887.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,936,449.00	71,089,608.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,198,200.00	648,279.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,098,389.53</b>	<b>7,018,811.92</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>6,098,389.53</b>	<b>7,018,811.92</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,098,389.53	7,018,811.92
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>6,830,700.00</b>	<b>3,758,880.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>6,049,900.00</b>	<b>4,539,680.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,049,900.00</b>	<b>4,539,680.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>6,049,900.00</b>	<b>4,539,680.00</b>
222001	Тоног төхөөрөмж	6,049,900.00	4,489,680.00
223001	Бусад хөрөнгө	-	50,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(6,049,900.00)</b>	<b>(4,539,680.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>780,800.00</b>	<b>(780,800.00)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>780,800.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>780,800.00</b>	<b>-</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	375,225,200.00	366,900,018.08
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	375,225,200.00	362,360,338.08
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	375,225,200.00	362,360,338.08
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	210,143,300.00	206,971,452.48
210101	Үндсэн цалин	150,529,600.00	150,015,497.48
210102	Нэмэгдэл	43,180,700.00	40,955,906.00
210105	Гэрээт ажлын хөлс	16,433,000.00	16,000,049.00

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29,082,900.00	27,595,231.80
210201	Тэтгэврийн даатгал	20,477,100.00	19,252,521.66
210202	Тэтгэмжийн даатгал	2,101,400.00	2,092,779.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,681,200.00	1,674,356.70
210204	Ажилгүйдлийн даатгал	420,300.00	451,360.51
210205	Эрүүл мэндийн даатгал	4,402,900.00	4,124,213.57
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	46,775,000.00	45,913,786.90
210301	Гэрэл, цахилгаан	8,275,000.00	4,556,964.90
210302	Түлш, халаалт	38,500,000.00	41,356,822.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,784,000.00	16,365,027.90
210401	Бичиг хэрэг	3,709,800.00	3,659,800.00
210402	Тээвэр, шатахуун	8,945,500.00	8,660,055.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,628,700.00	1,547,171.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,499,920.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	998,081.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	600,000.00	600,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	600,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,600,000.00	2,505,800.00
210604	Урсгал засвар	2,600,000.00	2,505,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,616,600.00	1,984,000.00
210702	Дотоод албан томилолт	3,616,600.00	1,984,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,523,400.00	3,174,740.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	379,400.00	364,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	131,200.00	131,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	142,000.00	132,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,100,000.00	2,100,000.00
210807	Газрын төлбөр	446,800.00	446,740.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	62,100,000.00	57,250,299.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,450,000.00	56,602,020.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	650,000.00	648,279.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>4,539,680.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	4,539,680.00
222001	Тоног төхөөрөмж	-	4,489,680.00
223001	Бусад хөрөнгө	-	50,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	375,225,200.00	366,119,218.08
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	346,264,800.00	357,563,618.08
132001	Орон нутгийн төсвөөс	346,264,800.00	357,563,618.08
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	28,960,400.00	8,555,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,660,400.00	8,555,600.00

1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	21,300,000.00	-
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>780,800.00</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	-	18.00
620001	Удирдах ажилтан	-	6.00
620002	Гүйцэтгэх ажилтан	-	12.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>14,813,208.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>14,813,208.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	14,813,208.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	325,620.00
210402	Тээвэр, шатахуун	-	325,620.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	14,487,588.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	14,487,588.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	14,862,038.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	14,862,038.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,141,288.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	13,720,750.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлангийн толилуулга, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор Г.Цэрэнлхам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/15 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Засгийн газрын бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж, мэргэшсэн төрийн албан хаагчдаар хүний нөөцийг бүрдүүлэн иргэдэд төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, тэгш хүртээмжтэй хүргэж, сумын хөгжилд манлайлагч болох зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Зорилтоо хэрэгжүүлэх тулд Бугат-Шинэ хөгжил 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган ИТХ-аар батлуулж хэрэгжилтийг ханган, Цахим Монгол арга хэмжээний хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод шуурхай хүртээмжтэй байдлыг ханган ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” гэж заасны дагуу тайлант онд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж ажиллаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 380,411.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,834.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,683.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, тайлант үеийн үр дүн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	780.80	-	-
Авлага	6,858.90	4,883.20	(1,975.70)
Бараа материал	74,311.80	72,740.30	(1,571.50)
Үндсэн хөрөнгө	1,094,039.40	1,235,244.30	141,204.90
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,175,990.90</b>	<b>1,312,867.80</b>	<b>136,876.90</b>
Богино хугацаат өр төлбөр	1,487.00	827.70	(659.30)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,174,503.90	1,312,040.10	137,536.20
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,175,990.90</b>	<b>1,312,867.80</b>	<b>136,876.90</b>

Тайлант хугацаанд орон нутгийн төсвөөс 364,533.6 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 12,862.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 8,555.6 мянган төгрөгийг бүрдүүлэн нийт 387,951.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 380,932.4 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулан, 7,018.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Авлага тайлант хугацаанд 4,883.2 мянган төгрөг болж, 1,975.7 мянган төгрөгөөр буурсан нь шунхлай петролимум ХХК-иас авах авлага, өмнөх оны цалингийн урьдчилгааг төлүүлж, цалингийн урьдчилгаа болон НДШ-ийн авлага үүссэнээс нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 72,740.3 мянган төгрөг болж 1,571.5 мянган төгрөгөөр буурсан нь бичиг хэргийн материал данснаас аж ахуй материал нөөцөлж, бичиг хэрэг, сэлбэг хэрэгслийн дансны өмнөх оны нөөцөлсөн үлдэгдлээс зарцуулснаас нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,235,244.3 мянган төгрөг болж 141,204.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр тавилга эд хогшил зэргийг бэлтгэж, аймгийн ИТХ-ын тогтоолоор ЕБС, цэцэрлэгээс складны барилга, СХС-аас шатахуун түгээх станц, ОНХС-ын хөрөнгө оруулалтаар хийгдэх барилга, тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийг шилжүүлэн авснаас нөлөөлсөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү бичилт хийгдээгүй, тайлант оны хуримтлагдсан үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээнд өөрчлөлт ороогүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 384,142.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 16,578.0 мянган төгрөгөөр бууруулж 367,564.8 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн тодотголоор төсвийн захирагчийн төсөвт өөрчлөлт ороогүй байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн 6 чиглэлийн арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 345,864.8 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 21,700.0 мянган төгрөг нийт 367,564.8 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 364,533.6 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, 8,555.6 мянган төгрөгийн түрээсийн орлого, принтерын засварын орлогоос өөрийн орлогоос бүрдүүлэн, урсгал үйл ажиллагаанд 366,900.0 мянган төгрөгийг зарцуулж, 6,189.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 366,900.0 мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 3,171.8 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1,487.7 мянган төгрөгөөр буюу 5.2 хувиар, байр ашиглалттай холбоотой зардал 861.2 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар, эд хогшил, урсгал засварын зардал 94.2 мянган төгрөгөөр буюу 3.7 хувиар, хангамж, бараа материалын зардал 418.9 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар, томилолт зочины зардал 1,632.6 мянган төгрөгөөр буюу 45.2 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн, ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 348.7 мянган төгрөгөөр буюу 9.9 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 4,849.7 мянган төгрөг буюу 7.9 хувиар тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр орлого дараах эх үүсвэрээс бүрдсэн байна. Үүнд:

- Ковид-19 цар тахалтай холбоотойгоор урьдчилан сэргийлэх зардалд 5,000.0 мянган төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцөөс, 1,000.0 мянган төгрөгийн аймгийн гамшгаас хамгаалах сангаас, иргэд аж ахуй нэгжээс 3,135.0 мянган төгрөгийн хандив,
- Хамтарсан багийн сургалтын зардалд 300.0 мянган төгрөгийг аймгийн ИТХ-аас,
- Хагас жилийн мал тооллогын зардалд 641.3 мянган төгрөгийг Статистикийн хэлтсээс,
- Нэр бүхий 10 өрхийн хүнсний дэмжлэгт 500.0 мянган төгрөгийг ХГБХЗХөгжлийн газраас,
- Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэхээр морин эргүүлийн урамшуулалд 748.8 мянган төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас,
- Сумын төвийн хог хаягдлын цэгийг ландфиллийн аргаар засварлах ажлын гүйцэтгэлийн зардлын дутуу санхүүжилт 3,536.9 мянган төгрөгийг аймгийн ОНХС-аас тус тус санхүүжсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилагдсан хөрөнгө 1,141.3 мянга, Төсвийн

байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 13,720.7 мянган төгрөг нийт 14,862.0 мянган төгрөгийн орлого хүлээн авч, тээвэр шатахууны зардлаар 374.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаар 14,487.6 мянга нийт 14,813.2 мянган төгрөгийг зарцуулан, 48.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Үндсэн хөрөнгийн 39201, 39203, 39205, 39207, 39214, 39301 дансанд 161 нэр төрлийн 196,265.9 мянган төгрөгийн хөрөнгө эзэмшилдээ байгаа элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох шаардлагатай байна. Үлдэх өртөг тэг үлдэгдэлтэй ашиглалтын хугацаа бүрэн дууссан хөрөнгөнд нэмж элэгдлийн зардал байгуулагдахгүйгээс тухай тайлант хугацааны элэгдлийн зардал үнэн зөв илэрхийлэгдэхгүй дутуу тайлагнагдаж байна.

Нэмэлт санхүүжилтийн данс болон үндсэн үйл ажиллагааны зориулалтаас бусад арга хэмжээний зардлыг зарцуулахдаа зардлын эдийн засгийн ангиллаар зарцуулахаар зарцуулалтын эрх олгоогүйгээс шалтгаалж, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн дүнтэй зөрүүтэй илэрхийлэгдэж байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 128 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба сар бүр 96 мэдээлэл, улирал бүр 4 мэдээлэл оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд:

✚ Шилэн дансны нэгдсэн [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлээгүй нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй,

✚ Мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж баталгаажуулаагүй нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй,

✚ Дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих дотоод хяналт хангалтгүй нь дотоод хяналтын талаарх Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын холбогдох заалттай нийцээгүй,

✚ Аудитаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүн болох 89,224.0 мянган төгрөгөөс 10 хувь буюу 8,922.4 мянган төгрөгийн хэмнэлт гаргахаар төлөвлөж тооцоогүй нь МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д ".....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасан шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөнийг Бугат сумын ЗДТГ-ын даргын 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 01/19 тоот албан бичгээр хэрэгжилтийг ирүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Өөрийн эзэмшилдээ байгаа боловч хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн ашиглалтын хугацаа дууссан ч ашиглагдаж байгаа хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн шинэчлэн тогтоох, нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулалтын эрх нээхдээ Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Мөн Сумын ИТХ-ын хуралдаанаар төсөв батлахдаа Бугат сумын Засаг даргын тамгын газрын орон тоог 18-аар баталсан нь “Сумдын засаг даргын тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоох тухай” Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоолоор 3001-5000 хүртэл хүн амтай суманд 16 байхаар байтал 2 орон тоогоор илүү цалингийн зардлыг баталж байгаад анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзлээ.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 356,548.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 10,670.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 345,878.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн үр дүнгийн тайланд 10,670.0 мянган төгрөгийн алдааг тусгаж баталгаажуулав.

Энэ нь УСНББОУС 27-д “санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой”, “Үнэн зөв толилуулга” нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг”, НББОУС 8-ын 10.Б.1-д “аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, санхүүгийн гүйцэтгэл ба мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлэх” заалтуудтай нийцэхгүй, “эрх ба үүрэг”, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

### **4.2 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 4.3 Албан шаардлага

4.3.1 Тавилга, багаж техникийн худалдан авах зардлаас 5 нэр төрлийн ширээ сандал, кресль, шкаф зэрэг конторын тавилга бэлтгэсэн байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэхь заалтыг хэрэгжүүлээгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байгаад Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчин тавилга эд хогшил бэлтгэсэн зөрчлийг таслан зогсоож, "Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" МУЗГ-аас гаргасан шийдвэрүүдийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

4.3.2 Цалингийн зардлаас таван сая төгрөгөөр дээш үнийн дүнтэй орлогын 341,339.0 мянган төгрөгийн 14 гүйлгээний мэдээлэл мэдээлээгүй, дараа жилийн төсвийн төсөл, хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан мэдээлээгүй, батлагдсан төсөв, 4-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ хугацаа хоцроосон нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"-д заасныг тус тус хэрэгжүүлээгүйд шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах, шилэн дансанд хугацаанд нь мэдээллийг иж бүрэн байршуулж, гарсан зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлээ.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүн болох 89,224.0 мянган төгрөгөөс 10 хувь буюу 8,922.4 мянган төгрөгийн хэмнэлт гаргахаар төлөвлөж тооцоогүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д ".....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" заалтыг хэрэгжүүлж ажиллах.

#### 2. Дотоод хяналттай холбоотой асуудал

##### 2.1. Илрүүлэлт:

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" гэж заасны дагуу 2020-2021 хичээлийн жилд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж ажиллаагүй байна.

##### 2.2. Өгсөн зөвлөмж:

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж, дотоод хяналт шалгалтын баг томилуулан ажиллуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Булган аймгийн Бугат сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Бугат сумын ЗДТГ	5	356,548.7	1	10,670.0	0	0	2	345,878.7	2	0